



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

ХҮҮХЭД , ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС

2013 оны санхүүгийн тайлан

Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахь хаягаар харилцана уу:

Тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

утас:70363040

E-mail: ch.enkh@yahoo.com

АГУУЛГА

ХУУДАС

Эсвэл: Аудитын менежер

Б.Батмөнх

Утас:70363047

Ахлах Аудитор Б.Эрдэнэзул

Аудитор ;С.Бат-Эрдэнэ

Утас: 70362442

Сэлэнгэ аймгийн Аудитын газар

Сүхбаатар сум 2-р баг ЗДТГ-ын

байрны өргөтгөлд

Аудит хийж дууссан тухай тайлан.....	1
Оршил.....	2
Санхүүгийн дотоод хяналт.....	3
Аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд.....	4
Аудитын санал дүгнэлт.....	4

Хавсралт 1: Тайлбар захидал

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудитлагдсан санхүүгийн тайлан



СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сүхбаатар, Сэлэнгэ аймаг
Утас/факс: 7036-3040

2014.02.09 № 02/02
танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮҮХЭД, ГЭР
БҮЛИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА П.ОЮУН ТАНАА

АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

Аймгийн Аудитын газар нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8.9, Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн аудитын тухай хуулийн 15.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтсийн 2013 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийдэг. Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн урьдчилсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг гүйцэтгэсэн болно.

Үүрэг хариуцлагын талаархи мэдэгдэл:

Сэлэнгэ аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс нь санхүүгийн тайлангаа Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Монгол Улсын Сангийн сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой журам, зааврын дагуу хугацаанд нь үнэн зөв гаргах үүрэгтэй. Энэхүү үүрэг хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, санхүүгийн тайлангуудыг аливаа материаллаг буруу илэрхийлэлгүйгээр бэлтгэх, үнэн зөвөөр толилуулахтай холбоотой дотоод хяналтыг хэрэгжүүлэх зэрэг багтана.

Тухайн санхүүгийн тайлан УСНББОУС, МУ-ын НББ-ийн тухай хууль, МУ-ын Сангийн Сайдаас баталсан нягтлан бодох бүртгэл, тайлагналын заавар журмын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь аймгийн Аудитын газрын үүрэг юм.

Аудитын санал, дүгнэлтийн үндэслэл:

Бид аудитаа Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний Аудитын газраас гаргасан санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн билээ. Эдгээр стандарт, гарын авлага нь санхүүгийн тайлан материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон

илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлсийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, баримталсан бодлого, хийсэн чухал тооцоолол, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг юм. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорилоор олж авсан нотлох зүйлс нь санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үндэслэл болсон.

Бидний олж авсан аудитын нотолгоо бидний гаргасан санал дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.


Сэлэнгэ аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн санхүүгийн тайланд аудит хийж дууссан тухай тайланд дурьдсанаар Нягтлан бодох бүртгэлийн зарчим, холбогдох хууль тогтоомж, заавар журмын зарим зүйл заалтыг зөрчсөнөөс үр дүнгийн тайланд зардлыг илүү тусгасан, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж хөрөнгө худалдан авсан зэрэг зөрчил илэрсэн байна.

Дээрхи илрүүлсэн нийт 1,413.6 мянган төгрөгийн алдаанаас аудитын явцад 564.6 мянган төгрөгийн алдааг залруулсан бөгөөд залруулагдаагүй үлдсэн 849.0 мянган төгрөгийн алдаа нь материаллаг түвшингээс бага байна.

Зөрчилгүй санал дүгнэлт:

Бидний дүгнэлтээр Сэлэнгэ аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлангууд нь УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой журам, зааврын дагуу материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА